



**ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2016 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/24

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн дотоод журмыг
шинэчлэн найруулах
ажлын хэсэг томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.6 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 149 дүгээр тогтоолын хавсралт “Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн найруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар томилсугай.

2. “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн найруулах ажлыг 2016 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор танилцуулж, батлуулахыг Ажлын хэсгийн ахлагч Б.Алтан-Очирт үүрэг болгосугай.

3. “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн найруулах ажлын хүрээнд нийт ажилтан албан хаагчдаас санал авч, тусгаж ажиллахыг Ажлын хэсгийн Нарийн бичгийн дарга Т.Түвшинзаяад үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /А.Нямхүү/-д даалгасугай.


ДАРГА  М.ГОНЧИГЖАВ

ЭМЭЭЛТИЙН
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ҮЙЛДВЭРЛЭЛ
ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨААТҮГ

ТТТ2340 № 0161709

3150600024

“Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл,
технологийн парк” орон нутгийн өмчит
төсөвт үйлдвэрийн газрын даргын 2016 оны
03 сарын 31 өдрийн 4/2 дугаар тушаалын хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч

- Б.Алтан-Очир Захиргаа, санхүү, төлөвлөлтийн хэлтсийн
Ахлах мэргэжилтэн

Гишүүд

- Г.Батням Нягтлан бодогч
- А.Нямхүү Дотоод хяналт-шинжилгээ үнэлгээ
хариуцсан мэргэжилтэн
- М.Жавхланчимэг Хөрөнгө оруулалтын төлөвлөлт хариуцсан
эдийн засагч

Нарийн бичгийн дарга

- Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

--oOo--